

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 08 дугаар сарын 14-ний өдөр

№001-03-Н012023

Улаанбаатар хот

### Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг эчнээ санал хураалтаар явуулах тухай

Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4 дэх заалт, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 65 дугаар зүйлийн 65.1, 65.4 дэх заалт, 67 дугаар зүйлийн 67.1, 67.5 дахь заалт, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3 дахь хэсэг, 73 дугаар зүйл, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ыг тус тус үндэслэн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс ТОГТООХ НЬ:

1. “Газар Шим Үйлдвэр”ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал(цаашид “Хурал” гэх)-ыг эчнээ санал хураалтаар явуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар Санхүүгийн Зохицуулах Хорооны 2012 оны 74 дүгээр тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн дүрмийн үлгэрчилсэн загвар”-т нийцүүлэн боловсруулсан “Газар Шим Үйлдвэр ХК-ийн дүрэм”-ийн шинэчилсэн найруулгыг батлах асуудлыг хэлэлцүүлсүгэй.
3. Хурал оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2023 оны 9 сарын 04-ны өдрөөр тогтоосугай.
4. Эчнээ санал хураалтын саналын хуудсыг Хувьцаа эзэмшигчдэд хүргүүлэх өдрийг 2023 оны 8 сарын 18-ны өдрөөр, хувьцаа эзэмшигчдээс саналын хуудас хүлээн авах сүүлийн өдрийг 2023 оны 10 сарын 02-ны өдрөөр тус тус тогтоосугай.
5. Хурал зарлах тухай мэдэгдлийг 2023 оны 8 сарын 17-ны өдрийн дотор Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Биржид тус тус хүргүүлж, Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудсаар дамжуулж хурлын зарыг нийтэд хүргэсүгэй.
6. Хурал хуралдуулах тухай зар мэдээг өдөр тутмын 2-оос доошгүй сонин болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2023 оны 8 сарын 21-ний дотор нийтэд мэдээлж, уг зарын давталтыг 2023 оны 9 сарын 06-ний өдөр анх зарласан хэлбэрээр дахин нийтэд мэдээлсүгэй.
7. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гаргах шийдвэрийн төсөл, танилцуулга, саналын хуудас зэрэг бусад холбоотой баримт бичгийг 2023 оны 8 сарын 21-ны өдөрт багтаан брокер, дилерийн компаниудад хүргүүлсүгэй.
8. “Газар Шим Үйлдвэр ХК-ийн дүрэм”-ийн төслийг нэгдүгээр хавсралтаар, Саналын хуудасны загварыг хоёрдугаар хавсралтаар, Хурлын нийтэд хүргэх зарын загварыг гуравдугаар хавсралтаар, Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материалын жагсаалтыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.
9. Хурлын даргаар “Газар Шим Үйлдвэр” ХК-ийн ТУЗ-ийн дарга /Ш.Алтанбагана/-ыг томилсугай.
10. Дараах нэр бүхий хүмүүсийг хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр томилсугай.
  - 10.1. Хурал зохион байгуулах комиссын дарга: Ц.Ганбат
  - 10.2. Хурал зохион байгуулах комиссын гишүүд: Б.Энхбилэг, С.Батчимэг

11. Хувьцаа эзэмшигчдийн Хурлын материалтай танилцах нөхцөл боломжийг бүрдүүлж ажиллахыг Хурал зохион байгуулах комисс /Ц.Ганбат/-д даалгасугай.
12. Хурлын Тооллогын Комиссоор Өмгөөллийн Сноу Хилл Консалтанси ХХН-ийг томилж, дараах бүрэлдэхүүнтэйгээр ажиллуулсугай.
  - 12.1. Тооллогын комиссын дарга: А.Солонго
  - 12.2. Тооллогын комиссын гишүүд: М.Даваажав, А.Тайван
13. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар шийдвэрлэсэн асуудал болон холбогдох бусад материалыг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан хугацаанд Монголын Хөрөнгийн Бирж болон Санхүүгийн Зохицуулах Хороонд хүргүүлэхийг хурал зохион байгуулах комиссын дарга /Ц.Ганбат/ болон Өмгөөллийн Сноу Хилл Консалтанси ХХН-д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Ш.АЛТАНБАГАНА